

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь	Үр нөлөө
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ						
1	Мал аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтын бэлтгэлийн дүнгийн тухай 2016.11.16 55	2. Цас ирхэй бүс нутагт отроор яваа малчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх, явуулын үзлэг хийх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Отроор өвөлжих малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар тухайн орон нутгийн удирдлагуудад ажлын чиглэл өгөх, өвчлөлөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг холбогдох газруудад хариуцуулах	Отроор өвөлжих малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар тухайн орон нутгийн удирдлагуудад ажлын чиглэл өгч ажиллаа. Мөн мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээг үзүүлж ажиллахыг холбогдох газруудад хариуцуулан ажиллаж байна.	50%	Өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдана.
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					50%	

Биелсэн:0
Хэрэгжих шатанд:1
Хугацаа болоогүй:0
Тасарсан:0
Үнэлгээгүй ажил:0

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь	Үр нөлөө
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ						
1	Үндэсний чанарын хөтөлбөр батлах тухай 2016.06.28 №344	3. Хөтөлбөрт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 2016 онд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт дарамт учруулахгүйгээр олон улсын байгууллага, гадаад, дотоодын зээл, тусламж, холбогдох төсвийн эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэлийн Засаг дарга нар т даалгасугай.	Хөтөлбөрт тусгагдсан холбогдох заалтын дагуу байгууллагын хэмжээнд нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллах	Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай 2016 оны А/635 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрмийг 2016 оны 10 дугаар сарын 27 –ны Нийслэлийн Засаг даргын А/758 захирамжаар батлагдсан. Батлагдсан дүрмийн дагуу Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс нь шинээр байгуулагдсан 2017 онд хөтөлбөрт тусгагдсан холбогдох заалтын дагуу байгууллагын хэмжээнд нэгдсэн төлөвлөгөө боловсруулна.	Үнэлгээгүй ажил /2016/	Хүнсний аюулгүй байдлыг ханган иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
2	Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2016.06.13 №322	2.1 Мал аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөө боловсруулж, батлуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллах;	Засаг даргын албан даалгаврыг гаргуулах Төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Засаг даргын 2016 оны 02 албан даалгаврын 11 заалт бүхий арга хэмжээг тусган хэрэгжүүлэхээр 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдөр гаргуулан дүүргүүдэд 04/222 дугаартай албан бичгээр хүргүүлэн ажиллалаа. Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 14 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаа. Мөн 6 дүүргийн Засаг даргын захирамжийг гаргуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллалж, тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэв.	100%	Нийслэлийн мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах бүрдэнэ.
		2.2 Энэ тогтоолын хавсралтаар баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;	Малын тоонд үндэслэн аюулгүйн нөөц бүрдүүлэх өвс, тэжээлийн тооцоог гарган дүүргүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангах Аюулгүйн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх	Нийслэлд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх чиглэлээр дүүрэг бүрт ажлын чиглэл өгч, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд 403.7 мянган толгой мал байгаагаас 2016-2017 онд хонин толгойд шилжүүлснээр 1.0 сая толгой мал өвөлжих мэдээтэй байна. Нийслэлийн хэмжээнд аюулгүйн нөөцөд 530 тн өвс, 400 тн тэжээл бэлтгэх тооцоо гарсан бөгөөд 125 тн өвс, 27 тн тэжээлийг нөөцөлсөн. Дүүргүүд цаг хүндэрсэн үед хэрэглэх нөөц хөрөнгийг НЗД-ын нөөцөд тусган ажиллаж байна.	70%	Аюулгүйн нөөцийн өвс тэжээлийг бүрдүүлснээр мал аж ахуйн эрсдлээс хамгаална.
		2.3 Сум дундын болон аймаг дундын отрын бүс нутаг, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоог өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан тогтоож, хэрэгжилтийг тухайн бүс нутгийн өөрөө удирдах байгууллага, хамгаалалтын захиргаатай хамтран зохион байгуулах;	Отроор өвөлжиж, хаваржих малын тоог гарган аймаг, сумдын удирдлагуудтай гэрээ байгуулах ажиллах	Нийслэлийн 2015 оны малын тоонд үндэслэн отроор өвөлжих малын судалгааг дүүрэг бүрээр гарган ажиллалаа. Нийслэлийн хэмжээнд өөр аймаг сумдын нутагт 228 өрхийн 48801 толгой мал отроор өвөлжиж, хаваржих мэдээтэй байна. Эдгээрээс Багануур дүүргийн 34 өрхийн 41000 толгой	100%	Отроор өвөлжих өрх, малын тоог тодорхойлох, отроор өвөлжих хаваржих боломж бүрдэнэ.

				<p>мал Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаанд отроор өвөлжих хүсэлт гаргасан бөгөөд энэ ажлын хүрээнд 2016 оны 09 дүгээр сард ХХААХҮЯ-ны сайд П.Сэргэлэн болон албаны бусад хүмүүстэй отрын бүс нутагт ажиллалаа. 2016 оны 10 дугаар сарын 06-нд Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын зөвлөл хуралд холбогдох удирдлагуудыг оролцуулан гэрээ байгуулан ажиллаж, малчин өрхүүдэд эмнэлэг болон бусад үйлчилгээг орон нутгаас үзүүлэх талаар ажлын чиглэл өгч ажиллалаа.</p>		
	2.4 Шаардлагатай зарим хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх арга хэмжээ авч, өөр аймгийн нутагт хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулах;	Мэдээг дүүргээс авч нэгтгэн ажлын явцыг цаг хугацаанд мэдээлж, тайлагнах	Хадлангийн мэдээг 2016 оны 08 дугаар сарын 25-аас эхлэн дүүргүүдээс авч нэгтгэн долоо хоног бүр ХХААХҮЯ-нд хүргүүлэн ажиллалаа. Нийслэлийн хэмжээнд хадлангийн талбай хомс байдгаас малчид өөр аймаг, сумдаас болон зах зээлээс худалдан авч өвс, тэжээлийг нөөцлөн авсан байна. Нийслэлийн хэмжээнд 9911.5 тн өвс, 1200 тн ногоон тэжээл, 2703 тн үйлдвэрийн тэжээл, 511тн гар тэжээл, давс хужир 821 тн бэлтгэсэн мэдээтэй байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг удирдлагууд болон холбогдох газарт тухай бүр тайлагнаж, тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.	100%	Өвөлжилтийн бэлтгэл хангагдан холбогдох газарт мэдээ тайлан хүргэгдэнэ	
	2.5. Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчин, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах;	Мал эмнэлгийн үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай шуурхай гүйцэтгэх арга хэмжээг авч ажиллах	<p>2016 оны 10 дугаар сарын байдлаар мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 761,5 мянган толгой мал, амьтныг хамруулсан. Үүнээс:</p> <p>Мал, амьтны гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 162,9 мянган хонь, шүлхийн 1, 2 дугаар ээлжийн вакцинжуулалтад 138,2 мянган толгой мал, бруцеллэзын вакцинжуулалтад 99,1 мянган толгой төл малыг хамрууллаа.</p> <p>Паразиттах өвчнөөс сэргийлэх туулгалтын арга хэмжээнд 31.3 мянган толгой бод, 207.8 мянган толгой бог мал, боловсруулалтын арга хэмжээнд 35.4 мянган толгой бод, 159.6 мянган толгой бог мал, цагаан хорхойн туулгалтанд 14.4 мянган толгой нохой, паразит өвчнөөс сэргийлэх угаалгын арга хэмжээнд 18,1 мянган толгой бод мал, 221,6 мянган толгой бог мал, нийт 688,2 мянган толгой мал, амьтныг хамруулсан байна.</p> <p>Мал, амьтны хашаа байр 1374 буюу 382,7 м2, авто тээврийн хэрэгсэл 384, мал, амьтны тоног хэрэгсэл 83, 53 худаг уст цэг буюу 14,6 м2, зоорь агуулах, түүхий эд хадгалах цэг, худалдааны төвийн байр,</p>	100%	Мал эрүүлжих боломж бүрдэнэ.	

				<p>боловсруулах үйлдвэр нядалгааны газар 166 буюу 558,0 м2, мал, амьтны сэг зэм, гоц халдварт болон халдварт өвчний голомтын 234,8 м2, бэлчээрийн 94,1 м2, нийт 1667,3 мянган м2 талбайд мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийг технологийн дагуу, мал, амьтан, хүний биед сөрөг нөлөөгүй ариутгал халдваргүйтгэлийн бодисоор хийж гүйцэтгэсэн байна. Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/728 дугаар захирамжаар Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа шүлхий өвчинд мэдрэмтгий мал, амьтныг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг бүрэн хийж дуусгаад байна.</p>		
		<p>2.6 Орон нутгийн төсвийн болон төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгөөр шинээр худаг гаргах, бэлчээрийн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлын явцад хийх гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах;</p>	<p>Орон нутгийн болон төсвийн хөрөнгөөр шинээр худаг гаргах</p>	<p>Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд “Бэлчээрийн менежмент” төслийн хүрээнд СХД-т 2 худгийг 59,9 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр гаргасан. Бэлчээрийн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлыг ХХААХҮЯ-нд санал хүргүүлж, дүүргүүдэд зохион байгуулах чиглэл өгсөн.</p>	100%	<p>Мал аж ахуйн усан хангамж сайжирна.</p>
		<p>2.7. Малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэрэг мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг малчин өрх бүрээр сайтар хангуулах;</p>	<p>Малчдыг хувийн бэлтгэлээ хангах талаар албан даалгаварт тусган хэрэгжилтийг хангуулах</p>	<p>Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг малчин өрх бүрээр сайтар хангуулах, өрх бүрийн хувийн бэлтгэлийг сайтар хангуулах талаар Засаг даргын албан даалгаварт тодорхой тусган, ажлын чиглэл өгч ажилласан бөгөөд хашаа, саравч, уст цэгийг засварлах, тохижуулах, түлээ түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэрэг ажлуудын биелэлт хангагдсан байна.</p>	100%	<p>Малчдын хувийн бэлтгэл хангагдана.</p>
		<p>2.8. ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийг сайтар бэлтгэж, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах;</p>	<p>Тариалалт, ургалтын явц болон ургац хураалтын үеэр нийслэлд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн талбайгаар явж мэдээ судалгааг бодит болгох, шинэчлэх, заавар зөвлөгөө өгч ажиллана.</p>	<p>2016 оны 06 сарын 23-24-ны өдрүүдэд энэ жилийн тариалалт болон ургалт, 08 дугаар сарын 10-12-ны эртийн ургац хураалтын байдалд зөвлөгөө өгч ажиллалаа. Тус ажлаар нийт 26 аж ахуй нэгж, 40 гаруй өрхийн тариалангийн 240 гаруй хүлэмж 125 га ил талбайн тариалалттай танилцсан хүлэмжийн таримлуудад хуурамч гуалах өвчин ихээхэн гарсныг ариутгал болон бусад арга хэмжээг авах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. 2016 онд нийслэлд газар тариалан эрхэлдэг 2874 өрх, 66 аж ахуй нэгж нийт 869 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж байна. 2016 ургац хураалтын үед цаг уурын мэдээлэл авч авч дүүргүүдийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнүүдээр дамжуулан тариаланчдад мэдээлэл хүргэн ажилласан. Мөн энэ оны хаврын тариалалт, ургац хураалтад зориулан ХХААХҮЯ, Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан БНХАУ-д үйлдвэрлэсэн газар тариалангийн</p>	100%	<p>Өвөлжилтийн бэлтгэл хангагдан тариаланчдад ургац хураалтын зөвлөгөө өгч, цаг уурын мэдээлэл хүргэгдэн ургацаа хамгаалж, урьдчилан сэргийлнэ.</p>

				зориулалттай 25 морины хүчтэй трактор 50 ширхгийг Нийслэлийн газар тариалан эрхлэгчдэд 3 жилийн хугацаатай хөнгөлттэй зээл олголоо.		
		2.9. аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах зорилгоор шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, түргэн тусламжийн машин, багаж хэрэгслээр дэмжлэг үзүүлэх;		Арга хэмжээг цаг тухай бүр холбогдох газруудтай хамтран зохион байгуулж ажиллах талаар албан даалгаварт тусган хэрэгжилтийг хангуулах чиглэл өгч ажиллаж байна. /Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Мал эмнэлгийн газраас дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой./	Үнэлгээгүй ажил /2016/	Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Мал эмнэлгийн газраас дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой
		2.10. орон нутагтаа болон отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаарх судалгааг үндэслэн эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх хуваарь гаргаж аймаг, сумын эмнэлгийг ажиллуулах.		Нийслэлээс 2016-2017 оны өвөл, хавар өөр аймаг, сумдын нутагт 230 өрх отроор өвөлжиж, хаваржих бөгөөд тэдгээр өрхүүдэд эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх талаар тухайн орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. /Нийслэлийн Эрүүл мэндийн газраас дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой/	Үнэлгээгүй ажил /2016/	Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон Мал эмнэлгийн газраас дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой
3	Дунд хугацааны стратеги батлах тухай 2015.10.05 №396	3. Дунд хугацааны стратегийн зорилт, арга хэмжээг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харъяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагын дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулах ажлыг эхлүүлэх, аж үйлдвэрийн бүсийн ерөнхий төлөвлөлт, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах	Дунд хугацааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Налайх хотын барилгын материалын үйлдвэрлэл /120га/, Хан-Уул дүүргийн Шар хөчийн хоолойд хөнгөн үйлдвэрлэл /160га/, Багануур дүүрэгт нүүрс гүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх /403,3га/, ҮТП-ыг байгуулах ажлыг эхлүүлж, бэлтгэл ажлыг зохион байгуулах Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газруудыг байгуулсан. Эмээлт, Налайх ҮТП-ийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, газрын доорхи усны эрэл хайгуул, технологийн түвшний үнэлгээ, эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажил, Эмээлтийн ҮТП-ийн инженерийн шугам сүлжээ, авто замын ажлын зураг төслүүд, Налайхын ҮТП-ийн оффиссын барилга, парк доторхи 2км сайжруулсан шороон зам зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг хийж дуусгаад байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдэд тулгамдаж байгаа асуудлын талаар санал асуулга явуулж, судалгааны дүн, тайлан мэдээг НУЗ-ийн хуралд танилцуулсан. “Эмээлт хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийн техник технологийн түвшний үнэлгээ”-г хийлгэж хүлээн авсан. Багануур дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн тусгай зөвшөөрөл гарсан. Эмээл, Налайхын паркийн тусгай зөвшөөрлийг авахаар холбогдох яаманд материалыг хүргүүлсэн.	90%	Экспортын баримжаатай, импортыг орлох, хувийн хэвшилд түшиглэсэн, дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэл хөгжих боломж бүрдэнэ.

4	Хурдан морины бүсийн уралдааны 2016 оны хуваарийг тогтоох тухай 2016.02.08 №91	3. Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд уралдааны дүрмийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр явуулахыг холбогдох аймгийн болон нийслэлийн Засаг дарга, Монголын морин спорт, уяачдын холбоонд тус тус даалгасугай.	Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд уралдааны дүрмийн дагуу зохион байгуулалтын өндөр төвшинд, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган зохион байгуулахад оролцох	Монгол морьдыг эрлийз морьдоос ялган тусад нь уралдуулах үүлдэрлэг байдлаар ялгах ажлын хэсэгт Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Б.Гантулга орж ажиллалаа.	100%	Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд уралдааны дүрмийн дагуу зохион байгуулагдна.
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					96%	

Биелсэн:1
Хэрэгжих шатанд:2
Хугацаа болоогүй:0
Тасарсан:0
Үнэлгээгүй ажил:1